



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 191

Улаанбаатар хот

Г “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх, үнэлгээ өгөх заавар”-ыг батлах тухай Т

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13.1 дэх заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх, үнэлгээ өгөх заавар”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэхүү зааврыг 2013 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 156 дугаар тогтоолоор батлагдсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагаанд газар дээрх шалгалт хийх, үнэлгээ өгөх заавар”-ыг 2013 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.
4. Батлагдсан зааврын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.



000341

Санхүүгийн зохицуулах хорооны  
2013 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн  
191 дүгээр тогтоолын хавсралт

УХА0410 5043239

## ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ГАЗАР ДЭЭРХ ШАЛГАЛТ ХИЙХ, ҮНЭЛГЭЭ ӨГӨХ ЗААВАР

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү зааврын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид Хороо гэх/-ноос хадгаламж, зээлийн хоршоо /цаашид “ХЗХ” гэх/-ны үйл ажиллагаа, санхүүгийн байдлыг газар дээр нь шалгаж<sup>1</sup>, Хадгаламж, зээлийн хоршооны тухай болон холбогдох бусад холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагуудаас мөрдүүлэхээр батлан гаргасан дүрэм, журам, заавар, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлт, хэрэгжилт, ХЗХ-ны санхүү, төлбөрийн чадвар, үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлон үнэлгээ, дүгнэлт өгч, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээ авах, зөрчил, дутагдлыг арилгуулахад оршино.

1.2. Газар дээрх шалгалт нь зорилгоосоо хамаарч иж бүрэн болон хэсэгчилсэн байдлаар хийгдэх ба “иж бүрэн шалгалт”-аар шалгалтанд хамрагдах хугацааны бүх нягтлан бодох бүртгэлийн баримт материалд тулгуурлан үйл ажиллагааг бүхэлд нь нэг бүрчлэн шалгаж, үнэлэлт дүгнэлт өгөх бол “хэсэгчилсэн шалгалт”-аар тухайн цаг үеийн шаардлага, нөхцөл байдлаас шалтгаалан, тодорхой цаг хугацаанд үйл ажиллагааны аливаа нэг хүрээг хэсэгчилсэн байдлаар шалгаж үнэлэлт, дүгнэлт өгнө.

1.3. Шалгалтын ажлын хэсэг нь ХЗХ-ны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд хийгдэх газар дээрх шалгалтыг Хорооны даргын баталсан удирдамжийн дагуу хугацаанд нь, чанартай гүйцэтгэх, тайлан дүгнэлтийг бичих, үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх ажлыг зохион байгуулах ба ингэхдээ дараах үзүүлэлтүүдийг заавал тооцож үнэлгээ, дүгнэлт өгнө. Үүнд:

- 1.3.1. өөрийн хөрөнгийн хүрэлцээ;
- 1.3.2. активын чанар;
- 1.3.3. удирдлагын чадвар;
- 1.3.4. үйл ажиллагааны үр дүн;

<sup>1</sup> Хороо шаардлагатай тохиолдолд ХЗХ-ны үйл ажиллагаанд төрийн эрх бүхий бусад хяналт, шалгалтын байгууллагатай хамтарсан шалгалтыг хийж гүйцэтгэх ба энэ тохиолдолд хамтарсан шалгалтын ажлын хэсэг нь энэхүү журмыг ерөнхий удирдлага болгоно.

### 1.3.5. төлбөр түргэн гүйцэтгэх чадвар

1.4. Дээрх үзүүлэлтүүдийг тооцож үнэлгээ, дүгнэлт өгөхдөө үзүүлэлт бүрийг тодорхойлох хүчин зүйлс буюу хавсралтад заасан үндсэн болон харгалзах хүчин зүйлийг тооцно.

1.5. Газар дээрх шалгалтын талаарх үнэлэлт, дүгнэлтийг үндэслэн ХЗХ-ны үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварын байдалд өгөх нэгдсэн үнэлгээг үзүүлэлт тус бүрт өгсөн үнэлгээг тус зааврын 6 дугаар хавсралтад заасны дагуу холбогдох хувиар жигнэж, дараах байдлаар газар дээрх шалгалтын нэгдсэн үнэлэлтийг өгнө. Үнд:

“Сайн” буюу “1”

“Хангалттай” буюу “2”

“Дунд” буюу “3”

“Хангалтгүй” буюу “4”

“Муу” буюу “5”

Тухайн ХЗХ-нд газар дээрх шалгалт хийх хугацаандаа өмнөх шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнг авч үзэн санхүүгийн үзүүлэлтийн өсөлт, бууралт, хандлагыг тодорхойлно.

1.6. Хэсэгчилсэн шалгалтыг хийж гүйцэтгэсэн тохиолдолд үнэлгээ, дүгнэлт өгөхдөө тухайн үзүүлэлтийн үнэлгээгээр тооцно.

### *Хоёр. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ*

2.1. Шалгалтын ажлын хэсэг нь энэ зааврын 1 дүгээр хавсралтад заасны дагуу өөрийн хөрөнгийн хүрэлцээний хүчин зүйлсийг үнэлж, дүгнэхдээ өөрийн хөрөнгө, нийт активын зохистой харьцаа Хорооноос тогтоосон шаардлагыг хангаж байгаа эсэхийг тооцон, тухайн ХЗХ-ны эрсдэлийн хүрээ болон түүний чанар зэргийг үндэслэнэ:

2.1.1. гишүүдийн нийт болон нэг гишүүний оруулсан хувь хөрөнгийн хэмжээ нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх;

2.1.2. нөөцийн сангийн хэмжээ нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх.

### **Гурав. Активын чанар**

3.1. Шалгалтын ажлын хэсэг нь энэ зааврын 2 дугаар хавсралтад заасны дагуу активын чанарын хүчин зүйлсийг үнэлж, дүгнэхдээ балансын болон балансын гадуурх хүндрэлтэй, чанаргүйд ангилагдсан, хугацаандаа төлөгдөөгүй, хуримтлуулж тооцоогүй, нөхцөл нь өөрчлөгдөж шинэчлэгдсэн активын түвшин, хандлага, активын эрсдэлийн сангийн хүрэлцээ,

чанаргүй активыг тодорхойлох, удирдах болон эргэн төлүүлэх чадвар, зээлийн багцын чанар, зээлийн бодлого, журам, зааврын хэрэгжилт, балансын гадуурх дансдаас үүсч болзошгүй зээлийн эрсдэл, активын төвлөрөл, нийт активт эзлэх зээлийн зохистой харьцааг хангасан байдал, зээлийн удирдлагын үр дүнтэй байдал, эрсдэлийг тодорхойлох журам, заавар, хяналт болон мэдээллийн систем зэргийг үндэслэнэ.

3.1.1. цэвэр зээлийн өрийн үлдэгдэл нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх;

3.1.2. нийт зээлд эзлэх чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх;

3.1.3. активын эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлт;

3.1.4. нэг гишүүн болон нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон нийт зээлийн дүн нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх;

3.1.5. өмчлөх бусад хөрөнгө нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх;

3.1.6. цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх.

### 3.2. Харгалзах хүчин зүйл:

3.2.1. нийт активт орлого оруулдаггүй активын эзлэх хувь, хэмжээг тооцох;

3.2.2. зээлийн бодлогын баримт бичиг, түүний хэрэгжилт, зээлийн хорооны үйл ажиллагаа буюу зээл олголт, хяналт, эргэн төлөлт:

а/ зээлийн барьцаа хөрөнгийн хэмжээ, чанар;

б/ шалгалт хамрах хугацаанд олгосон, төлөгдсөн зээлийн хэмжээ;

3.2.3. зээл болон бусад активтай холбогдсон хууль тогтоомж, журам, зааврыг мөрдөн ажиллаж байгаа эсэх;

3.2.4. нийт активт эзлэх хугацаа хэтэрсэн болон чанаргүй активын хэмжээ, түүний өсөлт, бууралтын шалтгааныг тодруулах, багасгах талаар авч байгаа арга хэмжээ.

## Дөрөв. Удирдлагын чадвар

Шалгалтын ажлын хэсэг нь дараах хүчин зүйлийг үндэслэн энэ зааврын З дугаар хавсралтад заасны дагуу удирдлагын чадварт үнэлгээ, дүгнэлт өгнө. Үүнд:

4.1. Удирдлагын чадварын чанарын хүчин зүйлсийг үнэлж, дүгнэхдээ ХЗХ-ны үйл ажиллагаатай холбоотой үзүүлэлтүүд хангагдаж байгаа эсэх, удирдлага нь үйл ажиллагаанд үүсч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, хэмжих, хянах чадвартай эсэхийг үндэслэнэ.

4.1.1. энэ журмын бусад дөрвөн үзүүлэлтийн дундаж үнэлгээ;

4.2. Харгалзах хүчин зүйл:

4.2.1. Хорооноос хийсэн өмнөх газар дээрх шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт, шалгалтын үр дүнгээр авсан арга хэмжээний чанар, үр дүнгийн байдал;

4.2.2. активын бусад эрсдэлийг тодорхойлох, хэмжих, удирдах, хянах чадвартай эсэх;

4.2.3. бүх гишүүдийн хурлыг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх, тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хороог хуулийн дагуу байгуулсан эсэх, тэдгээр нь хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа тогтмол явуулж байгаа эсэх;

4.2.4. ХЗХ нь салбарын үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтийн талаарх мэдээллийг хэрхэн цутгуулдаг, хоршооны удирдлагын үйл ажиллагаа болон санхүүгийн мэдээлэлтэй гишүүд танилцах нөхцлийг бүрдүүлсэн байдал;

4.2.5. холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн дүрэм, журам, заавраа боловсруулан, батлуулж, мөрдөж байгаа байдал;

4.2.6. ХЗХ-ны гүйцэтгэх захирлыг хуульд нийцүүлэн томилсон байдал, гүйцэтгэх захирал болон ажилтнууд нь хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа байдал;

4.2.7. санхүүгийн тайлан, мэдээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хугацаанд нь үнэн зөв гаргадаг эсэх, аудитын байгууллагаар баталгаажуулсан байдал.

#### **Тав. Үйл ажиллагааны үр дүн**

Шалгалтын ажлын хэсэг нь дараах хүчин зүйлийг үндэслэн энэ журмын 4 дүгээр хавсралтад заасны дагуу үйл ажиллагааны үр дүнгийн чанарын хүчин зүйлсийг үнэлж, дүгнэхдээ хуримтлагдсан орлогоор өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх чадвар, үйл ажиллагааны үр дүнгийн түвшин, хандлага болон тогтвортой байдал, үйл ажиллагааны үр дүнгийн чанар болон эх үүсвэр, уламжлалт бус, гэнэтийн орлого зардлаас хамаарах үйл ажиллагааны үр дүнгийн хамаарал, төсөв, төлөвлөгөө, түүний зохистой систем, удирдлагын мэдээллийн системийн зохистой байдал зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэнэ.

5.1.1. активын өгөөж;

5.1.2. шалгалт хамрах хугацааны активын өгөөжийн өсөлт, бууралт (ХЗХ-ны цэвэр орлогын түвшинг өмнөх он, улирлуудтай харьцуулсан өсөлт бууралт, түүний чиг хандлага, өөрчлөлтийн шалтгааныг тодруулах);

5.1.3. үйл ажиллагааны зардлын хэмжээ нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх.

### **Зургаа. Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар**

Шалгалтын ажлын хэсэг нь дараах хүчин зүйлийг үндэслэн энэ зааврын 5 дугаар хавсралтад заасны дагуу төлбөр түргэн гүйцэтгэх чадварт үнэлгээ, дүгнэлт өгнө. Үүнд:

6.1. Үндсэн буюу чанарын хүчин зүйл:

Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын чанарыг үнэлж дүгнэхдээ бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн өсөлт, бууралтын хандлага, тогтвортой байдал, богино хугацаат, хэлбэлзэл өндөртэй эх үүсвэрээс хамаарах хамаарал, энхүү богино хугацаат эх үүсвэрээр урт хугацаат активыг санхүүжүүлсэн байдал, нийт активт эзлэх хөрвөх чадвар сайтай активын хэмжээ, активыг борлуулах боломж, төлбөрийн чадварын хэрэгцээг хангах чадвар, төлбөрийн чадвартай холбоотой бодлого, заавар журмын зохистой байдал, түүний хэрэгжилт, эх үүсвэрийн удирдлагын стратеги, удирдлагын мэдээллийн систем болон эх үүсвэр татах нөөц төлөвлөгөө, төлбөрийн чадварын эрсдэлийг тодорхойлох, хэмжих, хянах болон ажиглах удирдлагын чадвар, балансын болон балансын гадуурх дансд дахь эх үүсвэрийн хэмжээ зэрэг үзүүлэлтийг харгалзана.

6.1.1. төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх;

6.1.2. банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээл, тогтвожилтын сангийн санхүүгийн туслалцааны санхүүжилтээр авсан зээл нь зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангасан эсэх, хугацаандаа төлөгдөж байгаа байдал.

6.2. Харгалзах хүчин зүйл:

6.2.1. бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөд эзлэх богино хугацаат өр төлбөрийн хэмжээ болон авлага, өр төлбөрийн төлөгдөх хугацааны уялдаа, зээл ба бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаа:

а/ актив, эх үүсвэрийн удирдлага, тэдгээрийн төлөгдөх хугацааны уялдаа, зээл, татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаа;

б/ нийт татан төвлөрүүлсэн хөрөнгөд эзлэх богино хугацаат өр төлбөрийн хэмжээ.

6.2.2. бусдад төлөх өр төлбөрийн үлдэгдэл, төлбөр тооцоо саатуулсан эсэх, саатуулж байсан бол хэмжээ, шалтгаан, шийдвэрлэсэн байдал.

### **Долоо. Нэгдсэн үнэлгээ өгөх**

Шалгалтын ажлын хэсэг нь ХЗХ-ны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд газар дээрх шалгалтын нэгдсэн үнэлгээ, дүгнэлтийг энэ зааврын 6 дугаар хавсралтад заасны дагуу өгөхдөө дараах зарчмыг баримтална. Үүнд:

7.1. Шалгалтын ажлын хэсгийн гишүүд нь батлагдсан ажил үүргийн хуваарийн дагуу өөрсдийн шалгасан энэ журмын 2-6 дугаар бүлгүүд дэх таван үзүүлэлт тус бүрээр ажлын хэсгийн ахлагчтай хамтран үнэлгээ, дүгнэлт өгнө.

7.2. Шалгалтын ажлын хэсгийн ахлагч нь бусад гишүүд бүртэй хамтран өгсөн үнэлгээний нийлбэрийн арифметик дундгийг тооцоолон ХЗХ-ны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд нэгдсэн үнэлгээ өгч, шалгалтын хэсгийн бүх гишүүд гарын үсэг зурж, улсын байцаагчийн тэмдэг дарж баталгаажуулна.

7.3. Нэгдсэн үнэлгээний дүнгээс хамаарч ХЗХ-ны үйл ажиллагаа, санхүүгийн байдлыг дараах байдлаар үнэлж, дүгнэнэ. Үүнд:

7.3.1. нэгдсэн үнэлгээ 1-ээс 1.6 хүртэл байвал “Сайн” буюу хэвийн үйл ажиллагаатай;

7.3.2. нэгдсэн үнэлгээ 1.6-аас 2.6 хүртэл байвал “Хангалттай” буюу эрсдэлд өртөж болзошгүй;

7.3.3. нэгдсэн үнэлгээ 2.6-аас 3.6 хүртэл байвал “Дунд” буюу хяналт, шалгалтын арга хэмжээ авах нөхцөл бүрдсэн;

7.3.4. нэгдсэн үнэлгээ 3.6-аас 4.6 хүртэл байвал “Хангалтгүй” буюу төлбөрийн чадвар муудаж болзошгүй;

7.3.5. нэгдсэн үнэлгээ 4.6-аас 5 хүртэл байвал “Муу” буюу төлбөрийн чадваргүй.

7.4. Шалгалтын ажлын хэсэг тухайн ХЗХ-ны үйл ажиллагаанд өгсөн нэгдсэн үнэлгээнд холбогдох үндэслэлийг тодорхой тусгана.

7.5. Шалгалтын ажлын хэсэг нь ХЗХ-ны үйл ажиллагаа, тухайн болон ирээдүйн санхүүгийн нөхцөл байдлын бодит хүчин зүйлийг харгалзан нэгдсэн үнэлгээг бууруулж эсхүл дээшлүүлж болно. Ингэхдээ чухам ямар бодит нөхцөл байдлыг харгалзсан үндэслэлээ нарийвчлан тодорхойлж, шалгалтын дүгнэлтэд тусгасан байна.

7.6. Энэ журмын 1-6 дугаар хавсралтаар тооцсон үнэлгээг арифметик дунджаар тооцоолох, мөн бусад харгалзах хүчин зүйлийг тусган ХЗХ-ны үйл ажиллагаа, санхүүгийн

байдалд нэгдсэн үнэлгээ өгч, шалгалтын хэсгийн бүх гишүүд, улсын байцаагч нар гарын үсэг зурж, улсын байцаагчийн тэмдэг дарж баталгаажуулна.

7.7. Шалгалтын ажлын хэсэг нь шаардлагатай гэж үзвэл шалгалт хийсэн ХЗХ-нд тухайн ХЗХ-ны үйл ажиллагаа, санхүүгийн байдалд өгсөн нэгдсэн үнэлгээ болон шалгалтын тайлан, бусад акт, материалыг танилцуулахаас өмнө Бичил санхүүгийн газрын удирдлагад урьдчилан танилцуулна.

7.8. ХЗХ нь шалгалтын ажлын хэсгээс өгсөн нэгдсэн үнэлгээг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд шалгалтын тайлан, үнэлгээтэй танилцсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Хорооны Улсын ахлах байцаагчид бичгээр гомдол гаргаж болно.

#### **Найм. Хариуцлага**

8.1. Хянан шалгагч нь хууль тогтоомжоор олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд нэгдсэн үнэлгээгээр дунд болон түүнээс доош үнэлгээ авсан ХЗХ-нд холбогдох арга хэмжээг авч хариуцлага ногдуулна.

Хавсралт 1

ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ

| ХҮЧИН ЗҮЙЛ  | ЖИГНЭХ ХУВЬ | САЙН /1/           | ХАНГАЛГТАЙ /2/                           | ДУНД /3/                                 | ХАНГАЛГГҮЙ /4/                        | МУУ /5/   | ҮНЭЛГЭЭ |
|---|-------------|--------------------|--|--|---------------------------------------|---|---------|
| 1 УНДСЭН ХҮЧИН ЗҮЙЛ   |             |                    |  |  |                                       |   |         |
| 1.1 Гишүүдийн оруулсан нийт хувь хөрөнгийн хэмжээ нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгур Үзүүлэлтийг хангаж байгаа эсэх | 15 %        | тогтмол биелүүлдэг | 3-аас доошгүй улирал дараалан биелүүлсэн | 2 улирал эсвэл улирал ээлжээн биелүүлсэн | сүүлийн 3 улирал дараалан биелүүлэгүй | сүүлийн 3 улирал дээши хугацаагаар дараалан биелүүлэгүй |         |
| 1.2 Нэг гишүүний оруулсан хувь хөрөнгийн хэмжээ нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгур Үзүүлэлтийг хангаж байгаа эсэх   | 25 %        |                    |  |  |                                       |   |         |
| 1.3 Неецийн сангийн хэмжээ нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалгур Үзүүлэлтийг хангаж байгаа эсэх                        | 60 %        | тогтмол биелүүлдэг | 3-аас доошгүй улирал дараалан биелүүлсэн | 2 улирал эсвэл улирал ээлжээн биелүүлсэн | сүүлийн 3 улирал дараалан биелүүлэгүй | сүүлийн 3 улирал дээши хугацаагаар дараалан биелүүлэгүй |         |
|   | 100 %       |                    |  |  |                                       |   |         |
|   |             |                    |  |  |                                       |   |         |

## АКТИВЫН ЧАНАР

| ХҮЧИН ЗҮЙЛ  | ЖИГНЭХ ХУВЬ | САЙН /1/                               | ХАНГАЛТТАЙ /2/                    | ДУНД /3/                          | ХАНГАЛТУЙ /4/                 | МУУ /5/                              | ҮНЭЛГЭЭ                              |
|---|-------------|--|-----------------------------------|-----------------------------------|-------------------------------|--------------------------------------|--------------------------------------|
| <b>1 УНДСЭН ХУЧИН ЗҮЙЛ</b>  |             |  |                                   |                                   |                               |                                      |                                      |
| 1.1 Цэвэр зээлийн өрийн үлдэгдэл нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалтуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх   | 1.5 %       | Нэгтгээлийн дундаж хувиас хамгийн бага | Нэгтгээлийн дундаж хувьтай бага   | Нэгтгээлийн дундаж хувьтай тэнцүү | Нэгтгээлийн дундаж хувьтай их | Нэгтгээлийн дундаж хувиас хамгийн их | Нэгтгээлийн дундаж хувиас хамгийн их |
| 1.2 Нийт зээлд эзлэх чанаргүй зээшийн өрийн үлдэгдэл  | 1.5 %       | 5 хувь хүртэл                          | 5-10 хувь хүртэл                  | 10-30 хувь хүртэл                 | 30-50 хувь хүртэл             | 50 ба гүүнээс дээш                   | 50 ба гүүнээс дээш                   |
| 1.3 Активын эрдээлийн сангийн хүрэлцэний үзүүлэлт   | 1.5 %       | 100 хувь байгуулсан                    | 91-ээс дээш хувь байгуулсан       | 71-90 хувь байгуулсан             | 30-50 хувь байгуулаагүй       | 51-ээс дээш хувь байгуулаагүй        | 51-ээс дээш хувь байгуулаагүй        |
| 1.4 Нэг тишүүн болон нэгдмэл сонирхолтой этгээдэд олгосон нийт зээлийн дун нь Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалтуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх | 1.5 %       | Нэгтгээлийн дундаж хувиас хамгийн бага | Нэгтгээлийн дундаж хувьтай тэнцүү | Нэгтгээлийн дундаж хувьтай тэнцүү | Нэгтгээлийн дундаж хувьтай их | Нэгтгээлийн дундаж хувиас хамгийн их | Нэгтгээлийн дундаж хувиас хамгийн их |
| 1.5 Хорооноос тогтоосон зохистой харьцааны шалтуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх;  | 1.5 %       | Нэгтгээлийн дундаж хувиас хамгийн бага | Нэгтгээлийн дундаж хувьтай тэнцүү | Нэгтгээлийн дундаж хувьтай тэнцүү | Нэгтгээлийн дундаж хувьтай их | Нэгтгээлийн дундаж хувиас хамгийн их | Нэгтгээлийн дундаж хувиас хамгийн их |
| 1.6 Цэвэршүүлсэн Үндсэн хөрөнгө нь  | 5 %         | Нэгтгээлийн дундаж хувиас хамгийн бага | Нэгтгээлийн дундаж хувьтай тэнцүү | Нэгтгээлийн дундаж хувьтай их     | Нэгтгээлийн дундаж хувьтай их | Нэгтгээлийн дундаж хувиас хамгийн их | Нэгтгээлийн дундаж хувиас хамгийн их |
| <b>2 ХАРГАЛЗАХ ХҮЧИН ЗҮЙЛ</b>   |             |  |                                   |                                   |                               |                                      |                                      |
| 2.1 Нийт активт орлого оруулдагүй активын эзлэх   | 5 %         | Нэгтгээлийн дундаж хувиас              | Нэгтгээлийн дундаж хувьтай        | Нэгтгээлийн дундаж хувьтай        | Нэгтгээлийн дундаж хувьтай    | Нэгтгээлийн дундаж хувьтай           | Нэгтгээлийн дундаж хувьтай           |

|     |   |  |  |  |  |  |
|-----|---|--|--|--|--|--|
|     | хувь, хэмжээг тоодох  | хамгийн бага   | бага   | тэнцүү   | их   | хамгийн их   |
| 2.2 | Зээлийн бодлогын баримт бичиг, түүний хэрэгжилт, зээлийн хорооны Үйл ажиллагаа буюу зээл олголт, хяналт, эргэн төлөлт | Зээлийн хуваарыт эргэн төлөлтийн хэмжээ 91-ээс дээш хувь | Зээлийн хуваарыт эргэн төлөлтийн хэмжээ 81-90 хувь | Зээлийн хуваарыт эргэн төлөлтийн хэмжээ 71-80 хувь | Зээлийн хуваарыт эргэн төлөлтийн хэмжээ 61-70 хувь | Зээлийн хуваарыт эргэн төлөлтийн хэмжээ 60-аас доош хувь |
| 2.3 | Зээл болон бусад активтай холбогдсон хууль тогтоомж, журам, зааврыг мөрдөн ажиллаж байгаа эсэх                        | 5 %  | хангасан   |  |  | хангагүй   |
| 2.4 | Зээлийг холбогдох журам, зааврын дагуу ангилсан эсэх  | 5 %  | 100 хувь ангилсан                                  | 91-ээс дээш хувь ангилсан                          | 71-90 хувь ангилсан                                | 30-50 хувь ангилгаагүй                                   |
|     | ҮНЭЛГЭЭ   | 100 %  |  |  |  | 51-ээс дээш хувь ангилгаагүй                             |

## УДИРДЛАГЫН ЧАДВАР

| ХҮЧИН ЗҮЙЛ  | ЖИГНЭХ<br>ХУВЬ | САЙН<br>/1/ | ХАНГАЛТТАЙ<br>/2/ | ДУНД<br>/3/ | ХАНГАЛГҮЙ<br>/4/ | МҮҮ<br>/5/ | ҮНЭЛГЭЭ |
|---|----------------|-------------|-------------------|-------------|------------------|------------|---------|
| <b>1 УНДСЭН ХҮЧИН ЗҮЙЛ</b>  |                |             |                   |             |                  |            |         |
| 1.1 Энэхүү журмын бусад 4 үзүүлэлтийн дундаж унэлгээ /арифметик дунджаар тооцоолно/   |                |             |                   |             |                  |            |         |
| 2 ХАРГАЛЗАХ ХҮЧИН ЗҮЙЛ  |                |             |                   |             |                  |            |         |
| 2.1 Хорооноос хийсэн омнох газар дээрх шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт, шалгальтын үр дунгээр авсан арга хэмжээний чанар, Үр дүнгийн байдал   |                |             |                   |             |                  |            |         |
| 2.2 Активын бусад эрсдэлийт тодорхойлох, хэмжих, удирдах, хянах чадвартай эсэх  |                |             |                   |             |                  |            |         |
| 2.3 Бүх гишүүдийн хурлыг хуулийн дагуу зохион байгуулсан эсэх, тэргүүлэгчдийн зөвлөл, хяналтын зөвлөл, зээлийн хороог хуулийн дагуу байгуулсан эсэх, тэдгээр нь хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа тогтмол явуулж байгаа эсэх |                |             |                   |             |                  |            |         |
| 2.4 ХЗХ нь салбарын үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтийн талаарх мэдээллийг хэрхэн цутгуулдаг, хоршооны удирдлагын үйл ажиллагаа болон санхүүгийн мэдээлэлтэй гишүүд танилцах нөхцлийг бурдуулсэн байдал                           |                |             |                   |             |                  |            |         |
| 2.5 Холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн дүрэм, журам, заавраа боловсруулан, батлуулж, мөрдэж байгаа байдал;  |                |             |                   |             |                  |            |         |
| 2.6 ХЗХ-ны гүйцэтгэх захирлыг хуульд нийцүүлэн томилсон байдал, гүйцэтгэх захираал болон ажилтнууд нь хууль тогтоомжийг хэрэгжүүлж  |                |             |                   |             |                  |            |         |

|  |       |  |  |
|--|-------|--|--|
|  |       |  |  |
|  |       |  |  |
| байгаа байдал  |       |  |  |
| Санхүүгийн тайлан, мэдээг холбогдох хууль тогтоомжийн дагуу хутсаанд нь үнэн зөв гаргадаг эсэх, аудитын байгууллагаар баталгаажуулсан байдал | 10 %  |  |  |
| ҮНЭЛГЭЭ  | 100 % |  |  |

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

| ХҮЧИН ЗҮЙЛ  | ЖИГНЭХ ХУВЬ | САЙН /1/   | ХАНГАЛТТАЙ /2/                         | ДУНД /3/                         | ХАНГАЛТГҮЙ /4/                   | МҮҮ /5/                          | ҮНЭЛГЭЭ                          |
|---|-------------|--|--|----------------------------------|----------------------------------|----------------------------------|----------------------------------|
| <b>1 УНДСЭН ХҮЧИН ЗҮЙЛ</b>  |             |  |  |                                  |                                  |                                  |                                  |
| 1.1 Активын өгөөж (Тайлант хугацааны татварын өмнөх цэвэр орлого/Нийт активын дундаж)   | 30 %        | Нэгтгэлийн дундаж хувиас хамгийн бага                          | Нэгтгэлийн дундаж хувиас бага          | Нэгтгэлийн дундаж хувьтай тэнцүү |
| 1.2 Шалгалт хамрах хугацааны активын өсөлт, бууралт (ХЗХ-ны цэвэр орлогын түвшинг өмнөх он, улирлуулдай харьцуулсан өсөлт бууралт, түүний чиг хандлага, өөрчлөлтийн шалтгааныг тодруулах) | 30 %        | Нэгтгэлийн дундаж хувиас хамгийн их өссөн, бага өссөн, буурсан | Нэгтгэлийн дундаж хувиас дээгүүр өссөн | Нэгтгэлийн дундаж хувьтай тэнцүү |
| 1.3 Уйл ажиллагааны зардлын хэмжээ нь Хорооноос тогтоосон зохицой харьцааны шалтуур үзүүлэлтийг хангаж байгаа эсэх  | 40 %        | хангасан   |  |                                  |                                  | хангагүй                         |                                  |
|   | ҮНЭЛГЭЭ     | 100 %  |  |                                  |                                  |                                  |                                  |

**ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР**

Хавсралт 5

| ХҮЧИН ЗҮЙЛ |   | ЖИГНЭХ ХУВЬ | САЙН /1/                     | ХАНГАЛГТАЙ /2/  | ДУНД /3/   | ХАНГАЛГТГҮЙ /4/                                 | МҮҮ /5/                                       | ҮНЭЛГЭЭ                                       |
|------------|---|-------------|------------------------------|---|--|---|---|---|
| 1          | ҮНДСЭН ХҮЧИН ЗҮЙЛ   |             |                              |   |  |   |   |   |
| 1.1        | Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын УЗҮҮЛЭЛТ НЬ Хорроноос тогтоосон зохицтой харьцааны шалгур УЗҮҮЛЭЛТИЙХ ХАНГАК БАЙГАА ЭСЭХ   | 45 %        | Тогтмол биелүүлдэг           | 3 улирал дараалан биелүүлсэн                          | 2 улирал эсвэл улирал ээлжлэн биелүүлсэн                     | СҮҮЛИЙН 3 УЛИРАЛ ДАРААЛАН БИЕЛҮҮЛЭЛТГҮЙ         | СҮҮЛИЙН 3 УЛИРАЛ ДАРААЛАН БИЕЛҮҮЛЭЛТГҮЙ       | СҮҮЛИЙН 3 УЛИРАЛ ДАРААЛАН БИЕЛҮҮЛЭЛТГҮЙ       |
| 1.2        | Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээл, тогтвржилтын сангийн санхүүгийн туслаалцааны санхүүжилтээр авсан зээл нь зохицтой харьцааны шалгур УЗҮҮЛЭЛТИЙХ ХАНГАСАН ЭСЭХ, хугацаандaa төлөгдөж байгаа байдал | 30 %        | тийм                         | -   | -  | -   | -   | УГҮЙ  |
| 2          | ХАРГАЛЗАХ ХҮЧИН ЗҮЙЛ  |             |                              |   |  |   |   |   |
| 2.1        | Авлага, өр төлбөрийн эргэн төлөгдхөх хугацааны харьцаа  | 15 %        | ХҮНДРЕЭЭС БҮРЭН ХАМГАЛАГДСАН | 1 жилээс дээш хугацааны дараа эрсдэлд өртөж болзошгүй | 2 улираас 1 жил хүргэл хугацааны дотор эрсдэлд орж болзошгүй | 2 улирлын хугацааны дотор эрсдэлд орж болзошгүй | 1 улирлын хугацаанд хүндэрэлд орх магадлалтай | 1 улирлын хугацаанд хүндэрэлд орх магадлалтай |
| 2.2        | Бусдад төлөх өр төлбөрийн үндэгдэл, төлбөр тооцоо саатуулж байгаагүй бол хэмжээ, шалтгаан, шийдвэрлэсэн байдал  | 10 %        | саатуулж байгаагүй           | саатуулж болзошгүй                                    | 1 улирал саатуулсан  | 2 улирал саатуулсан                             | 3-аас дээш улирал саатуулсан                  | 3-аас дээш улирал саатуулсан                  |
|            | ҮНЭЛГЭЭ   | 100 %       |                              |   |  |   |   |   |

**ХЭХ-НЫ УЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮ, ТӨЛВӨРИЙН ЧАДВАРЫН  
БАЙДАЛД ОГСОН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ**

| ДД | ҮЗҮҮЛЭЛТҮҮД                   | ЖИГНЭХ ХУВЬ | ШАЛГАЛТААР ӨГСӨН ҮНЭЛГЭЭ | ӨМНӨХ ШАЛГАЛТААР ӨГСӨН ҮНЭЛГЭЭ | ӨӨРЧЛӨЛТ |
|----|-------------------------------|-------------|--------------------------|--------------------------------|----------|
|    |                               | Үзүүлэлтээр | Жийнэснээр               |                                |          |
| 1  | ӨӨРИИН ХӨРӨНГИИН ХҮРЭЛЦЭЭ     | 20.00 %     |                          |                                |          |
| 2  | АКТИВЫН ЧАНАР                 | 20.00 %     |                          |                                |          |
| 3  | ҮДИРДЛАГЫН ЧАДВАР             | 30.00 %     |                          |                                |          |
| 4  | УЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДУН        | 15.00 %     |                          |                                |          |
| 5  | ТӨЛВӨР ТУРГЭНГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР | 15.00 %     |                          |                                |          |
|    | НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ               | 100.00 %    |                          |                                |          |

Жич 1. Бууруулсан эсхүл дээшшуулсан үнэлгээ бүрийн харгалзах үндэстэлийг тодорхой зааж бичнэ.

ҮНЭЛГЭЭ ӨГСӨН:

ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ:

/НЭР/

ШАЛГАЛТЫН АЖЛЫН ХЭСГИЙН ГИШҮҮД:

/НЭР/